

**АУДИТ ХИЙГДЭХ НЭГЖ: ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА**

ДОТООД АУДИТЫН НЭГЖ:

Дундговь аймгийн Санхүүгийн
хяналт, аудитын алба

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МАНДАЛГОВЬ ХОТЫН 14-Р
БАЙРНЫ ГАДНА ФАСАД, 14 ХУДГУУДЫГ СМАРТ КАРТЖУУЛАХ
АЖЛУУДАД ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН**

АУДИТЫН НЭР: Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны худалдан авах ажиллагааны тайлан, Мандалговь хотын 14-р байрны гадна фасад, 14 худгуудыг смарт картжуулах ажлуудад аудит хийх.

Огноо: 2020.03.18

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА:
АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ:
АУДИТЫН ТӨРӨЛ:
АУДИТЫН ХУГАЦАА:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ДОТООД АУДИТ
2020.03.02-2020.03.18

Дотоод аудитын нэгжийн дарга:
Багийн ахлагч :
Санхүүгийн хяналт шалгалтын
улсын ахлах байцаагч

Г.Зоригт

Г. Эрдэнэбаатар

Санхүүгийн хяналт шалгалтын
улсын байцаагч

Г. Энхтайван

АГУУЛГА

ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

1. ТАНИЛЦУУЛГА
2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ
 - 2.1 Аудитын зорилго
 - 2.2 Аудитын цар хүрээ
3. АУДИТЫН ҮР ДҮН
 - 3.1 Илэрсэн асуудлууд
 - 3.2 Дүгнэлт
 - 3.3 Зөвлөмж
4. ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Нэг. ТАНИЛЦУУЛГА.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын талаар:

2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэсээс ирүүлсэн бараа, ажил үйлчилгээний жагсаалтын дагуу боловсруулж аймгийн засаг даргаар батлуулан ажилласан бөгөөд 1 удаа тодотгол хийсэн байна. Уг төлөвлөгөөнд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын ХАА-ны төлөвлөгөө, тайлан бүрэн нэгтгэгдээгүй, нэгтгэж ажиллах талаар арга хэмжээ авсан зүйл байхгүй байна.

2019 оны худалдан авах ажиллагааны тайлангаар 226 бараа, ажил, үйлчилгээний 20,433,695.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Үүнээс: нийт 992,749.4 мянган төгрөгийн хэмнэлт бий болжээ.

Уг 226 худалдан авах ажиллагааны 23 буюу 10,2 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 56 буюу 24,8 хувийг харьцуулалтын аргаар, 138 буюу 61,1 хувийг шууд худалдан авалтаар 7 буюу 3,1 хувийг зөвлөх үйлчилгээгээр, 10 буюу 4,4 хувийг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус зохион байгуулсан байна. Үүнээс сумдад зохион байгуулсан 180 худалдан авах ажиллагааны 76,7 хувь нь шууд худалдан авалт байна.

Тус оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт Орон нутгийн өмчийн газар дээр 92,3 хувьтай, сумдын ЗДТГ дээр 85 хувийн хэрэгжилттэй тайлагнажээ.

Мэргэшсэн хүмүүсийн нөөц, боломжийн талаар:

Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулах эрх бүхий 193 мэргэшсэн албан хаагч байна. Үүнээс төрийн албан хаагч ... иргэн ... байна. Судалгаанаас харахад 2017 онд АЗ сертификат авсан 60 гаруй албан хаагчийн сертификатын хугацаа 2020 онд дуусахаар байгаа бөгөөд эдгээр хүмүүсийн ихэнх нь өмнөх онуудад тендер зохион байгуулахад тогтмол оролцож байсан туршлагатай хүмүүс байна. Тус онд 33 тендер шалгаруулалтад оролцсон 6 иргэний төлөөлөлд хууль, журмын дагуу 464,7 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Цахим тендер зохион байгуулалтаар Орон нутгийн өмчийн тендерийн бичиг баримтын үнэ болох 5,692.5 мянган төгрөг төвлөрсөн бөгөөд тус газар өөрийн нэмэлт санхүүжилтийн дансандаа төвлөрүүлэн албан томилолтын зардлын өрөнд 1,138.5 мянган төгрөг, дэмжлэг 1,554.0 мянган төгрөг, электрон самбар авахад 3,000.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Хоёр. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго

Дотоод аудитын хорооны тогтоолоор батлагдсан санхүүгийн хяналт, шалгалтын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, тус байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, итгэл үнэмшлийн баталгаа өгөх зорилготой. Мөн эрсдэлийн дүн шинжилгээ өгч, тулгарч буй асуудлыг дүгнэх, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгнө.

2.2 Аудитын цар хүрээ

Орон нутгийн өмчийн газрын худалдан авах үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэхдээ Улсын секторын дотоод аудитын гарын авлага, Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартууд, практик зөвлөмж, практик заавруудыг ашиглан удирдамжинд батлагдсан дараах цар хүрээнд хамрагдаж гүйцэтгэсэн болно. Үүнд:

1. “Төсвийн тухай” хууль
2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль
3. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль
4. “Шилэн дансны тухай” хууль
5. Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
6. Сангийн сайдын 2017 оны 365 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагаанд аудит хийх журам”
7. Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 07 тоот тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”
8. Сангийн сайдын 2012 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 194 тоот тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”
9. Бусад холбогдох хууль, журам заавар

Ирүүлсэн мэдээллийн дагуу холбогдох баримтуудад хяналт, шалгалтыг зохион байгуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай холбогдох заавар, дүрэм, журмуудтай хэрхэн нийцэж байгаа байдалтай танилцаж тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулахад чиглэгдлээ.

Дээрх эрх зүйн баримт бичгийн хүрээнд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Гурав. АУДИТЫН ҮР ДҮН

3.1 Илэрсэн асуудлууд

Асуудал 1. Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын байдал.

Шалгуур:

1. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль
2. “Шилэн дансны тухай” хууль
3. Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”

Бодит нөхцөл байдал:

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд улс, аймаг, сум орон нутгийн төсвөөр хийгдэх хөрөнгө оруулалтын 20,433,695.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 256 бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар

төлөвлөжээ. 2019 оны төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 15,911,000.0 мянган төгрөгийн 13, Мал эмнэлгийн газар, Өлзийт сумын 2 ажил захиалгаар нийт 15 худалдан авах ажиллагааны эрх шилжиж ирсэн бол аймгийн засаг дарга 459,949.4 мянган төгрөгийн 8 бараа ажлын худалдан авах ажиллагааг сумдын засаг дарга нарт эрх шилжүүлсэн байна.

2019 оны худалдан авах ажиллагааны тайлангаар 226 бараа, ажил, үйлчилгээний 20,433,695.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. Үүнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 15,911,000.0 мянган төгрөгийн 13, улсын төсвийн байгууллагуудын урсгал санхүүжилтийн 15,320.4 мянган төгрөгийн 1, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1,695,534.8 мянган төгрөгийн 19, замын сангийн 248,635.8 мянган төгрөгийн 2, орон нутгийн хөрөнгийн 524,362.0 мянган төгрөгийн 10, зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 56,000.0 мянган төгрөгийн 1, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 1,982,842.9 мянган төгрөгийн 180 худалдан авах ажиллагааг зохион байгуулж нийт 992,749.4 мянган төгрөгийн хэмнэлт бий болсон байна.

Тус онд Орон нутгийн өмчийн газар дээр зохион байгуулагдах худалдан авах ажиллагаанаас “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн засварын ажлын зураг төсөв болон зураг төсөв гэж батлагдсан зөвлөх үйлчилгээнүүдийн ажлын даалгаварууд, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Цагаандэлгэр сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажлын зураг төсөв оройтож ирсэн учир тендер шалгаруулалт хийгдээгүй байна.

Тус онд зохион байгуулсан 226 худалдан авах ажиллагааны 23 буюу 10,2 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 56 буюу 24,8 хувийг харьцуулалтын аргаар, 138 буюу 61,1 хувийг шууд худалдан авалтаар 7 буюу 3,1 хувийг зөвлөх үйлчилгээгээр, 10 буюу 4,4 хувийг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус зохион байгуулж тайлагнасан байна. Үүнээс сумдад зохион байгуулсан 180 худалдан авах ажиллагааны 76,7 хувь нь шууд худалдан авалт байна.

Шалгалтаар илэрсэн асуудал:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 онд зохион байгуулсан ХАА-ны төлөвлөгөө тайланд харьяа сум, байгууллагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан бүрэн нэгтгэгдээгүй, зөвхөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөн тайлагнасан байна. Мөн орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан нэгтгэгдээгүй байна.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны мэдээлэлд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, зохион байгуулсан тендерийн мэдээллийг байршуулаагүй.

3. Тус онд Адаацаг, Сайнцагаан, Дэлгэрцогт, Дэлгэрхангай, Цагаандэлгэр сумд, аймгийн Орон нутгийн хөгжлийн сан дээр шууд худалдан авалт хийх зорилгоор нэг төсөл арга хэмжээний төсвийг хувааж 2-3 төсөл арга хэмжээ болгон баталсан зөрчил илэрсэн.

4. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зураг төсвийн худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө 27,827.1 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг нэмэгдүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зөвлөхийн ажлын даалгавар ирээгүй тул тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Дүгнэлт: ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны тайлан дутуу нэгтгэгдсэн бөгөөд зохион байгуулсан тендерийн мэдээллийг хуулийн дагуу Шилэн дансанд мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

1. Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 2.5-д *“Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн харьяа төсөвт бүх байгууллага, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын тухайн онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг нэгтгэн журмын 2.4-т заасны дагуу баталж, тухайн онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсвийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. АЗ-ийн сертификаттай сумдын мэргэшсэн хүмүүсийн тоог нэмэгдүүлэх, чадавхжуулах талаар сум байгууллагуудтай хамтарч ажиллах.

3. Захиалагч нарын дараа оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний төслийг 8 дугаар сарын 15-ны дотор, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төсөв батлагдсанаас хойш 10 хоногийн дотор авч нэгтгэж, тайлагнах.

Асуудал 2. Мандалговь хотын 14 дүгээр байрны гадна фасадны ажлын худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт.

2.1 Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн талаар:

Мандалговь хотын 14 дүгээр байрны гадна фасадны ажлын төсвийг 2017 онд 4,900.0 мянган төгрөгөөр хийлгэсэн бөгөөд 2019 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр 134,949.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг аймгийн засаг даргаас Сайнцагаан сумын засаг даргад 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/62 дугаар захирамжаар эрх шилжүүлжээ. Сайнцагаан сумын засаг дарга 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/77 дугаар захирамжаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж үнэлгээний хороо анх 2019.04.03-ны өдөр хуралдан тендерийг 2019.04.04-2019.05.06- хүртэл нээлттэй зарлахаар шийдвэрлэжээ. Уг тендерт Сүлд хайрхан оюу ХХК-аас Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт тендерийн бичиг баримттай холбоотой гомдол ирүүлсний дагуу тендерийн нээлтийг сунган 2019.05.20-нд нээсэн байна.

Тендерт Ерөө эрдэс констракшн ХХК, Хархорин хаус ХХК, Батлюкс ХХК, Сүлд оюу хайрхан ХХК нар тендер ирүүлсэн бөгөөд уг оролцогчдын тендерийг үнэлгээний хороо үнэлээд шаардлага хангасан нэг ч тендер ирээгүй гэж дүгнэн тендерийг дахин 2019.06.04-2019.07.03-ний өдрийн 10:00 цагт хүлээн авахаар зарлажээ. Дахин зарласан тендерт Ерөө эрдэс констракшн ХХК 113,400.000 төгрөгийн, Гурвандэлгэр ХХК 115,252.841 төгрөгийн тендер ирүүлсэн бөгөөд үнэлгээний хорооноос Ерөө эрдэс констракшн ХХК-г хамгийн сайн тендер гэж үнэлэн гэрээ байгуулах тухай дүгнэлтийг захиалагчид хүргүүлж захиалагч 2019.08.06-ны өдөр гэрээ байгуулсан байна.

Уг ажлын гүйцэтгэгч Ерөө эрдэс констракшн ХХК нь гэрээний хугацаанд ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна. Ажлын төсөвт өртөгт багтсан зураг төсвийн 4,900.0 мянган төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд үлдээн авлага хаасан

бол захиалагчийн албаны зардал болох 2,057.1 мянган төгрөгийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын холбогдох дансанд шилжүүлж, зохиогчийн хяналт хийгдээгүй тул зохиогчийн хяналтын 1,028.6 мянган төгрөг сангийн дансанд үлдсэн байна. Уг худалдан авах ажиллагаанаас нийт дүнгээр 22,578.0 мянган төгрөг хэмнэсэн байна.

2.2 Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаан дээр гарсан асуудал:

1. Үнэлгээний хорооны гишүүдэд Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Төрийн бус байгууллагаас томилсон хүн байхгүй байгаа нь хуулийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй,

2. Үнэлгээний хорооны гишүүд үнэлгээний зааврын дагуу тендерүүдийг хянан үзсэн тухай баримт байхгүй, хянан үзэх маягтуудыг огт хэрэглээгүй байна.

3. Дахин нээлттэй тендер зарлахдаа ТББ-д өөрчлөлт оруулах эсэх талаар судалж үзэлгүй зарласан нь хуулийн 30.4.1-д “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, захиалагч дахин тендер зарлах тухай ямар нэгэн баримт бичиг үйлдээгүй байхад үнэлгээний хороо дахин тендер зарласан байна.

Дүгнэлт: Үнэлгээний хороо тендерийн бичиг баримтыг сайн боловсруулсан боловч ТООЗ-д заасан шаардлагуудыг хангасан эсэх талаар үнэлгээ хийхдээ тодорхой бичээгүй үнэлгээний маягтуудыг огт ашиглаагүй байгаа нь үнэлгээг хэрхэн хийсэн, хэр бодитой хийсэн нь нотлогдохгүй байна.

Зөвлөмж:

1. Хуулийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй,

2. Үнэлгээний зааврын дагуу тендерийг хянан үзэж маягтуудыг бүрэн бөглөж дүгнэлт гаргах.

3. Захиалагчийн шийдвэрийн дагуу тендер дахин зарлах.

4. Нээлттэй тендер шалгаруулалт дахин зарлах бол яагаад амжилтгүй болсон шалтгааныг судалж үзэх, судалсан тухай бичиг баримт үйлддэг байх.

Асуудал 3. “Мандалговь хотын гэр хороололын ус түгээх 14 худгийг смарт болгох тоног төхөөрөмж” нийлүүлэх худалдан авах ажиллагаанд хийсэн аудит /Ажил/

Шалгуур: Хууль журмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлсэн байх.

Бодит нөхцөл байдал: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр санхүүжигдэх “Мандалговь хотын гэр хороололын ус түгээх 14 худгийг смарт болгох тоног төхөөрөмж нийлүүлэх ажил”-ыг сонгон шалгаруулах

Үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/105 тоот захирамжаар байгуулан, үнэлгээний хорооны даргаар ТЗУХ-ийн дарга М.Цогзолмаа, гишүүдээр иргэний төлөөлөл Ц.Бямбацогт, СТСХ-ийн мэргэжилтэн С.Адъяасүрэн, “Дундговь-Ус” ОНӨАТҮГ-ын нягтлан бодогч О.Сэргэлэн, нарийн бичгийн даргаар ОНӨГ-ын ХАА /худалдан авах ажиллагаа/ хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Адъяасүрэн гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Уг ажлын даалгаврыг 2019.03.27-ны өдөр дээрх үнэлгээний хорооны гишүүд анхны хуралдаанаа хийж гүйцэтгэгчийг сонгох тендер зарлах, баримт бичгийг боловсруулан 2019 оны 3 дугаар сарын 28-нд тендерийг зарлан 2019.04.29 өдөр нээхээр болсон байна.

Ажлыг сонгох худалдан авах ажиллагааг нээлттэй тендерийн аргаар цахим тендерээр зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд тендерийн урилга “Зууны мэдээ” сонины 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 64 дугаарт хэвлэгдэн гарсан байна.

Тендер хүлээн авах эцсийн хугацаанд цахимаар тендерийн материалаа Итгэл тод харш ХХК, ЭХОМН ХХК, Тэлмэн нетворк ХХК, Эйч Ти Эл ХХК-ууд ирүүлсэнг 2019.05.03-ны өдрийн үнэлгээний хорооны 2 дахь хурлаараа хэлэлцэн шалгаруулж Эйч Ти Эл ХХК-ыг хамгийн бага үнэ, “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэн захиалагчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн байна. Үүний дагуу 2019.05.06-ны өдөр захиалагчид Эйч Ти Эл ХХК-тай 141,680,000 төгрөгийн гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн Үнэлгээний хорооны дүгнэлтийг хүргүүлсэн байна. Дүгнэлтэд хорооны гишүүн С.Адъяасүрэнгээс бусад гишүүд оролцон гарын үсгээ зурж баталгаажуулсан байлаа.

“Мандалговь хотын гэр хороололын ус түгээх 14 худгийг смарт болгох тоног төхөөрөмж” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтанд оролцсон “Тэлмэн нетворк” ХХК-аас “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргасан учир Сангийн яамны 2019.05.30-ны өдрийн 6-1/3511 тоот албан бичгээр тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түтгэлзүүлсэн. Сангийн яамны 2019.06.10-ны өдрийн 6-1/3809 тоот албан бичгээр захиалагчид гэрээ байгуулах эрх олгосон Эйч Ти Эл ХХК-ны тендерийн баримт бичигт ирүүлсэн техникийн үзүүлэлтийг хянан үзээд удирдлагын процессор нь “Raspberry” загварынх бөгөөд тендерийн баримт бичигт заасан Windows 7,8,10, андройд үйлдлийн системд ажиллах эсэхийг нягталж үзсэний үндсэн дээр тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийхийг мэдэгдсэн. Үүний дагуу 2019.06.25-ны өдрийн Үнэлгээний хорооны 3-р хуралдаанаар дээрх 4 ХХК-ийн цахимаар ирүүлсэн тендерийн материалыг дахин хянан үзэж шаардлагад нийцсэн нэгч тендер ирээгүй гэж үзсэн тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 30-р зүйлийн 30.1.1-д заасны дагуу бүх тендерээс татгалзаж, 30.4.1-д заасны дагуу дахин нээлттэй тендер зарлахаар шийдвэрлэсэн.

Үнэлгээний хорооны гишүүдийн ажлын хариуцлага сул, хайхрамжгүйгээс болж өмнө хуралдаанаар тендерт шалгарч гэрээ байгуулахаар болсон Эйч Ти Эл ХХК-ны тендерийн материал дахин үнэлгээгээр тендерийн баримт бичгийн ТШӨХ-ийн 5.3-ийн г-д заасан шалгуур үзүүлэлт, захиалагчийн техникийн даалгаварт одоогийн хэрэглэж байгаа ухаалаг худгийн серверийн программ хангамж болох Автохудаг 3 системтэй худгууд холбогдон ажиллах шаардлагатай гэсэн боловч тус

компани одоогийн суурилагдсан байгаа 3 худгийг өөрсдийн хөрөнгөөр нэг систем буюу өөрийн системд оруулахаар санал болгосон нь захиалагчийн техникийн даалгавар, тодорхойлолтод нийцээгүй тул “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 27.4-д заасны дагуу тендерээс татгалзсан нь хоног хугацаа алдаж, хүн хүчний болон материалын зардал нэмэгдэж тендер хүчингүй болоход нөлөөлсөн байна. Дахин тендер зарлахдаа тендерийн бичиг баримтанд ямар өөрчлөлт оруулсан талаар үнэлгээний хорооны гишүүдээс гарсан санал, баримт бичиг байхгүй байна.

Дахин зарласан тендерийн урилга Зууны мэдээ сонины 2019.08.20-ний өдрийн 165 дугаарт хэвлэгджээ. Үнэлгээний хорооны 2019.10.07-ны өдрийн 4-р хуралдаанаар, цахимаар дахин зарласан “Мандалговь хотын гэр хороололын ус түгээх 14 худгийг смарт болгох төхөөрөмж”-ийг нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулжээ. Цахим тендерт ЭХОМН ХХК, Эйч Ти Эл ХХК, Баялагговь ХХК-ууд материалаа ирүүлсэнээс гишүүдийн 100 хувийн саналаар Баялагговь ХХК-ийн тендерийг “хамгийн сайн” гэж үзэж гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсэн байна. Баялагговь ХХК 144,925,235 төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажилласан байна. Гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2019.12.02-ний өдрийн А/66 тоот тушаалаар томилогдсон Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүд 2019.12.13-ний өдөр 2812019 тоот “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт”-ийг бичин гарын үсгээр баталгаажуулан ашиглалтад авчээ. Гэрээнд заагдсан төсөвт өртөгөөс ГХБХБГ-т захиалагчийн албаны зардлын 2,511,112 төгрөг, 6.12-р худгуудын дулааны алдагдлыг бууруулах зорилгоор худгуудын дотор прүссээр рам зангидан голд нь 10-ийн хөөс хийн 2 талаас нь хавтан барьж дулаалах, вакум хаалга хийх, 14 худагт дифференциал автомат суурилуулах ажилд гарах зардлыг магадлашгүй ажлын зардлаас гаргахаар тохиролцсоны дагуу 2,511,112 төгрөгийг Баялагговь ХХК-д тус тус шилжүүлэн өгсөн байна.

Гэрээнд заагдсан төсөвт өртөгөөс зураг төсвийн ажлын зардал 300,000 төгрөг, зураг, төсөл зохиогчийн хяналтын зардал 1,255,556 төгрөгийг шилжүүлээгүй сангийн дансанд үлдсэн байна. Зураг, төсөл зохиогчийн хяналтыг ерөөсөө хийгээгүй байна. Уг худалдан авах ажиллагаанаас нийт дүнгээр 9,760.2 мянган төгрөг хэмнэсэн байна.

“Дундговь-ус” ОНӨАТҮГ, Өрхтий-өрөмт ХХК-тай 2018.10.10-ний өдөр “Зураг, төсөл боловсруулах ажлын гэрээ” байгуулан ажиллаж зураг төсвийн зардалд 2018.10.18-ны өдрийн 002399 тоот Төлбөрийн даалгавараар 300,000 төгрөгийг шилжүүлэн өгсөн байна.

Шалгалтаар илэрсэн асуудал:

1. Захиалагчийн хяналтын зардлыг ГХБХБГ-т шилжүүлэн өгсөн боловч гүйцэтгэсэн ажилд хэрхэн хяналт тавьсан талаар ямарч баримт материал байхгүй байна.

2. Хуулийн 47.4-д “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг *оролцуулна*” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй,

3. Үнэлгээний зааврын дагуу тендерийг хянан үзэж маягтуудыг бүрэн бөглөж дүгнэлт гаргах.

Дүгнэлт: Үнэлгээний хороо тендерийн бичиг баримтыг сайн боловсруулсан боловч ТООЗ-д /Тенднерт оролцогчид өгөх шааварчлага/ заасан шаардлагуудыг хангасан эсэх талаар үнэлгээ хийхдээ тодорхой бичээгүй үнэлгээний маягтуудыг огт ашиглаагүй байгаа нь үнэлгээг хэрхэн хийсэн, хэр бодитой хийсэн нь нотлогдохгүй байна.

Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн хяналт, аудитын албанд бичгээр ирүүлнэ.

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ

СХШ-ын УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

УЛСЫН БАЙЦААГЧ

Г. ЭРДЭНЭБААТАР

Г.ЭНХТАЙВАН

ТАНИЛЦСАН:

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙН ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.БАТ-ЭРДЭНЭ

Б.АДЪЯАСҮРЭН